



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/800

Булган сум

Оны шилдэг ажилтан шалгаруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын “Журам батлах тухай” 2021 оны А/605 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн шилдэг ажилтан шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.2024 оны шилдэг ажилтнаар шалгарсан иргэд, төрийн албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

2.Шилдэг ажилтнуудын мөнгөн шагнал, урамшуулалд шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3.Шилдэг ажилтнуудыг шагнаж урамшуулах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Д.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6324011196

12 дугаар сарын 25-ны/ний өдрийн 11800 дугаар
Аймгийн Засаг даргын 2024 оны
захирамжийн хавсралт

АЙМГИЙН 2024 ОНЫ ШИЛДГҮҮД

- 1.Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын аймгийн шилдэг түшээ:**
Дэмбэрэлийн Нарангэрэл–(Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарын бичгийн дарга)
- 2.Санхүүгийн салбарын оны шилдэг ажилтан:**
Батчулууны Солонго-(Татварын газрын Татварын Улсын байцаагч)
- 3. Боловсрол, соёл, урлагийн салбарын оны шилдэг ажилтан:**
Цэрэндавгын Дэмбэрэлмаа-(Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын лаборатори сургуулийн Биеийн тамирын багш)
- 4.Төрийн захиргааны салбарын оны шилдэг ажилтан:**
Дашзэвэгийн Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
- 5. Эрүүл мэнд, биеийн тамир, спортын салбарын оны шилдэг ажилтан:**
Гончигжавын Туяа-(Аймгийн Нэгдсэн эмнэлгийн цусны салбар төвийн бага эмч)
- 6. Хууль, хяналтын салбарын оны шилдэг ажилтан:**
Чагнаадоржийн Энхбаяр - (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга)
- 7.Нийгмийн хамгаалал, иргэний нийгмийн байгууллагын салбарын оны шилдэг ажилтан:**
Полоозын Саран–(Хөгжлийн бэрхшээлтэй иргэний Дүүрэн боргоцой хоршооны зөвлөх багш)
- 8.Үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын оны шилдэг ажилтан:**
Мэдэхгүйн Бадам-(Стандарт хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн)
- 9.Хүнс, хөдөө аж ахуйн салбарын оны шилдэг ажилтан:**
Байхуурын Пүрэвжаргал-(“Их мээж хайрхан” МЭҮН-ийн малын эмч)
- 10.Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын оны шилдэг ажилтан:**
Банзрагчийн Бямбаа-(Сэлэнгэ сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч)